

Д.НОРОВЫН “ТЭЖЭЭВЭР” ТУУЖИЙН УР ЧАДВАРЫН АСУУДАЛД

Д. Галбаатар *, Р. Алтансайхан *

1980-аад оны эхээр монгол утга зохиолын салбарт нарийн ур хийц шаарддаг хүүрнэл зохиолын дундаж жанр болох туужис зохиолын төрөлд амжилт олж, өөрийн бүтээлүүдээ уран дүрийн сэтгэл зүйг нарийн шинжилж, зохиолынхоо утга, үйл явдлын өрнөл, тайлал дахь холбоосыг тухайн цаг үедээ шинэлэг байдлаар даацтай нээсэн хүүрнэл зохиолын том төлөөлөгчийн нэг Далхаагийн Норов юм. Тэрээр Говь-Алтай аймгийн буйдхан суманд хүний бага эмчээр ажиллаж ахуйдаа хүүрнэл зохиолын богино хэлбэр өгүүллэг төрлөөр уран бүтээлийн гарааг эхлүүлж, 1980-аад оны дундаас тууж, уянгын богино өгүүллэгийн бүтээлээрээ их амжилт олоод зогсохгүй роман бичлэгийн томоохон төлөөлөгч болсон юм.

Тэдний дотроос Монгол Улсын Төрийн шагнал хүртсэн “Тэжээвэр”, “Орлогч” зэрэг уянга-сэтгэл зүйн хэв шинж бүхий туужис зохиолууд нь уянга-туульсын хосолмол хэв шинжийг хадгалсан, хэлбэр ба агуулга, зохиомж, ерөнхий бүтэц, байгуулалт, уран сайхны сэтгэлгээ-сэтгэл зүйн хэв маягуудыг зохистой хослуулсан шилдэг бүтээлүүд уншигчдын дунд их алдаршсан билээ. Тогтсон хэв маягт баригддаггүй, амьдралын жам ёсны талаарх ёс суртахууны нийтлэг сургаал, танин мэдэхүйн хийгээд намтарчлал бус шинжүүдээс нэлээд өөрөөр чөлөөтэй сэтгэсэн, амьдралын далд чанадын ертөнц буюу баатруудын сэтгэл зүйн дотоод хувьсал өөрчлөлтийг уянга-сэтгэл зүйн арга барилаар нээдэг онцлогтой юм. Тэрээр уран бүтээл, ялангуяа тууж, өгүүллэгийн хэрэг явдал болон өрнөлийн дотоод учир шалтгааныг нарийн нээх, зохиолын санаа, үүтгэл түлхээсээ зөв мэдэрч, гүн ухааны өнгө аясаар баяжуулж, нягт нямбай бодсон, сайн найруулгын хэв маягаараа үеийнхэн дотроо илэрхий ялгардаг.

Бид өмнө нь: “Тэжээвэр” туужийн Гөлгөөгийн дүрийг уянга-сэтгэлзүйн дүр, уран сайхны дүрийн төлөвшилд баатрын ухамсар-сэтгэхүй-сэтгэцийн хэлбэршлүүд нь хүрээлэн буй орчин, амьдрал ахуйн нөхцөлөөс үүдэн мэдрэхүй хийгээд ухамсарт өртсөн зүйлс байх ба ой санамж хийгээд субъектив хүчин зүйлс бүтээлийнх нь эх үүсгэл нь болжээ гэж үзсэн. Хүн эхийгээ хайрлах гэдэг ухамсар, оюун ухааны үйл биш. Энэ нь зүгээр төрөлхийн зөн билэг /инстикт/ болохыг Гөлгөөгийн эх дүрээс мэдэж болохыг, мөн хүүхэд ахуйн дурсамжууд хожим хойтод сэргэж, сэтгэх үйл явцад нөлөөлж, бие хүн, эсвэл түүний эсрэг хандуулах бөгөөд хүүхдийн дарамтлагдсан хүслийн “хор хөнөөл” тод томруун илэрч байхад нөгөө талаасаа сэтгэл зүйн баримтыг

* МУИС, Утга зохиол, урлаг судлалын тэнхим

* МУИС, Утга зохиол, урлаг судлалын тэнхим

/амьдрал дахь таагүй дурсамж/ ой санамжаас устгах боломжгүйг Гөлгөөгийн дүр тод нээжээ. Энэ нь З.Фрейдийн ухамсрыг мэдрэхүйн бүхий сонирхолтой өгөгдөхүүнээс эхлэл үндэс үүсгэлтэй гэж тодорхойлохгүй хэр нь ухамсарт бус зүйлсийг ухамсраас гарвальтай гэж үздэг рациональ үзэлтэй зөрчилдөж, харин эсрэгээрээ мэдрэхүй бол харин ч ухаалаг бус иррациональ шинжтэй гэсэн дүгнэлттэй нь санал нийлэхэд хүргэдэг.

Гөлгөөгийн дүр амьдралын хоорондох нарийн холбоосуудыг илтгэх үнэлэмж, сэтгэцийн дотоод зөрчил, хүчин зүйлстэй тэмцэлдэгч шинж байдал нь тухайн дүрээ сэтгэлзүйн дүрийн хэв маягаар бүтээсэн [Р.Алтансайхан, 2013] хэмээн тайлбарлаж болох юм. Үүнийг тодотгохын учир уран сайхны дүрийн хэв шинжийг онцлон авч үзсэн энэхүү өгүүлэлд туужийн зохиомж ба ур чадварын онцлогоос зарим нэг асуудлыг тодруулахыг хичээсэн билээ.

“Тэжээвэр” туужийн онцлогийн тухайд судлагсад, шүүмжлэгчид доорх байдлаар өгүүлжээ. “... түүний туужуудыг ажиглахад зохиолын зохиомж, өгүүлэмжид ардын дуу, зүүд, зүүрмэг зөн, совин билэг, домог-түүх, хий санааны юмс үзэгдэл, сүнс сүлд зэргийн хийсвэр шинж, сэтгэлгээ, бэлгэдлийн хүчин зүйлсийг агуулгад нийцүүлэн ашиглаж, туужийн учир шалтгаант холбоог чадварлаг сүлжин...”¹ гаргасан тухайд доктор С.Байгалсайхан: “Д.Норовын туужууд дүрийн сэтгэлзүйн сонирхолтой нээлтүүд болон ардын дуу, домгийн элементүүдийг өгүүлэмждээ нийцтэй ашиглах арга барилууд нь баатруудын ээдрээ түвэгтэй амьдралын нэгэн онцгой чухал үе агшныг ихээхэн хурц тод дүрслэн нээх чадвараараа өвөрмөц төдийгүй өөрийн гэсэн ур зүй, урлах эрдэм, уран чадвар бүхий тул энэ байдал нь уран зохиолын судлаач шүүмжлэгчдийн хараанд өртөж, өөрийн уран бүтээлийн судлалын эх суурийг тавьж чаджээ”² гэсэн тодорхойлолт нь их ханатай үнэлгээ гэж болно.

Д.Галбаатар “Д.Норовын зохиолууд энгүүн хүүрнэл яриа, нууцлаг байдал, санаанд оромгүй хурц зөрчил, бусад зохиолын гол дүр, баатруудын сэтгэл зүйн сонирхолтой нээлт, уянгын сайхан халил түрлэгтэй, ардын дуу, домгийн элементийг зохиолын ерөнхий агуулгадаа тохируулан оновчтой ашигласан, өгүүлэмжийн өрнөлийг маш хурц тод харуулдаг онцлогтой зохиолч юм” гэснээр профессор Д.Цэндээс “Зохиолч Д.Норовын зохиол бүтээлд өгсөн голч дүгнэлт болжээ”³ гэж үнэлсэн юм. Д.Цэнд уг зохиолын талаарх хувийн бодол санааг: “Д.Норовын бүтээл, ялангуяа туужис нь үйл явдал өрнөж болохуйц гэрэлт тод шугам, зохиомжийн нарийн сайн бодсон байгуулалт, бүдэгшсэн зөрчлийг нээх, хурцатгах чадвар буюу дүрийнхээ санаа сэтгэхгүйн ертөнц рүү нэвтэрч орох боломж нээсэн уран дүрслэл, хэл найруулгын яруу төгс чанар, ер шилдэг сайн зохиолд тавигддаг бүхий л шаардлагыг нарийн хангасан байдаг нь алт мөнгөний... дарханд л байх давтагдашгүй нарийн урлалыг санагдуулж байна”⁴ гэж үнэлжээ.

“Тэжээвэр тууж”-ийн дүрүүд ба “уянга-сэтгэл зүйн хэв шинж” гэх үнэлгээ санааг зарим нэг жишээ баримтад тулгуурлан уран дүрээ бүтээсэн байдал, арга барилын ялгарах гол онцлогийг дараах байдлаар тодруулъя.

¹ Оюунгэрэл Д (2009), “Хөх тавилангийн “хөх өнгө”-ний тухайд”, Монгол судлалын чуулган, МУБИС. УБ., 110-р тал.

² Байгалсайхан С (2014) нар, “Монголын орчин үеийн уран зохиолын түүх IY”, ШУА. ХЗХ. УБ., 176-р тал

³ Цэнд Д (2010), “Уран зохиол-миний амьдрал”, УБ., 129-р тал

⁴ Цэнд Д (2010), “Уран зохиол-миний амьдрал”, УБ., 129-р тал

Нэг, Уран дүр түүн дотор уянга-сэтгэлзүйн хэв шинжит дүрийг бүтээхэд баатрын дотоод ертөнцийг үйл явдлаас илүүтэйгээр сэтгэлийн зөрчил, гуниг бадрал, өшөө хорсол, хайр дурлал эдгээрийн өөрчлөлтийг хэрхэн нягт дүрсэлснээр тодорхойлж болох ба зохиолч Д.Норов үүнийг домог, зүүд, айдас, зөн совин, ёр билиг, бэлгэдлээр сэтгэж, уянга-сэтгэлзүйн уран чадамгай дүр бүтээдэг болохыг нь “Жаргалын булаг”, “Хөх сайрын чулуу”, “Хөх тавилан”, “Хар гэгээ” зэрэг бусад туужуудаас нь мөн харагдаж байна.

Туужид **айдас, түүнээс** үүтгэгдсэн өвөрмөц сэтгэлэг, заримдаа бүр сэтгэцийн гаж гэмээр аяг араншин илрэх нь элбэг. Түүнийхээ хэрээр туужийн хэрэг явдал, дүр хоорондын холбоосоор өгүүлэмж нь уран чадварлаг, сонирхолтой болсон нь олонтоо таарна. Гол баатар Гөлгөөгийн амьдрал нь “айдас”-аар дүүрэн юм. Тухайлбал: *“Би чинь тэжээвэр нохойн гөлөг нэртэй өслөө шүү дээ. Аав намайг өөрөөр нэрлэдэггүй байсан юм. Ээж нохой, би гөлөг нь... Бүх хүмүүс юмыг мартагнаж, саатаж, цэнгэл наадамд жолоо султгаж, ташуурч чаддаг байхад би хором төдий ч алмайрч, мартагнаж чаддаггүй. Өчүүхэн зүйлийг ч гэхнээ ямагт учир утгатай болгож, өөрийг болон бусдыг сэжиглэн хардаж, ажиглаж, түүнд хэрхэн хариулахаа бодож байдаг. Энэ бол миний зовлон, миний дутагдал”* гэж баатрын бодлоор өөрийн зан төлөвийг нээжээ. Түүний айдас, айдсаас үүтгэлтэй зан чанар, төлөв байдал нь хүний амьдралын хүслэн болсон амар жимэр амьдрах туйлын хүсэлтэй нь ямагт зөрчилдөнө. Гөлгөө бол сэтгэлт бүсгүй Цэнгэлийн нууц амраг, Гөлгөөд сэтгэл татагдсан Туяагийн аавын нөлөөгөөр хэлтсийн дарга болох ч боломжтой, бас сайдын шунаг хүсэлтэй эвлэрэхгүй охиныг нь орхиж, нууц амрагийг нь өөртөө татна. Мөн өөрийнхөө дурлалт бүсгүй Цэнгэлд царай өгөлгүй байсаар Цэнгэлийг бүх амьдралаа орхиж, өөр дээрээ ирүүлж байгаа үйл явдал нь эл баатрын бүхнийг тооцоолж бусдаас хариугаа авах, санасандаа хүрдэг зан чанар юм. Хуурамч найрагч болон Цогт зэрэг бусад дүрүүдтэй харилцахдаа өөрийнх нь зан чанар үргэлж ил тод илэрч байдаг. Гэвч эл зан төрхүүд нь Гөлгөөгийн дүрийг муутгахгүй төдийгүй тухайн цаг үе, нийгмийн шалиг самуун явдалтай албан тушаалтны бусармаг будангүй үйл хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл гэх олон талт зөрчил, асуудлуудыг хөндөж, уншигчдад зориуд ухааруулахыг зорьж бүтээсэн ёс суртахуунтай эерэг уран дүр юм.

Зохиолд **ёр билгээр** сэтгэн дүрслэх аргыг чадамгай ашигласан. Туужийн эхэнд: *“Энэ эзгүй газар нохой явамгүй юм гэж бодоод морио давирав. Гэвч нөгөө бараан юм алга. Юу байх билээ гэж бодолхийлэн гэлдэртэл морь дахин сэртэсхийв. Надаас төдий л холгүй хуурай цагаан сайрын хөл дээр гуринхайтсан болов уу гэмээр хөөвөр нь гуужиж гүйцээгүй хөх чоно зогсож байлаа”* гэж “би баатар”-ын эрэл бүтэлгүйтэх, эзгүй майхантай тааралдаж, айж ширвээтэх бүхнийг зөгнөсөн ёр билгийн шинжтэй аж.

Энэ тухайд доктор С.Байгалсайхан: *“Д.Норовын “Тэжээвэр” туужид гол баатар эзгүй хээр ганцаар мал хайж яваад нэгэн чонотой тааралдаж, айсандаа бие жихүүцэж, айдас төрөх авай. Гэв гэнэт эл аюултай амьтантай хээр эзгүй газар тааралдсан нь жир нэг тохиолдол бус баатрын цаашдын үйл хөдлөлд ямар нэг учир битүүлэг аймшигтай юм болохын ёр бэлгийг өгүүлжээ. Өөрөөр хэлбэл тэрхүү аймшигтай, учир битүүлэг юм болохыг зөгнөж, урьдчилан хэлсэн хэрэг.”*⁵ гэжээ. “Би” баатар Гөлгөөгийн майхнаар гурав дахиа очиход: *“Тэндээс мордох үедээ би майхны нь*

⁵ Байгалсайхан С (1998), “Уран дүрийн онолын лекцүүд”, УБ., 116-р тал.

зүүн хаяанд нэг хохимой байхыг харав. Салхинд өнхрөөд ирмээргүй юм. Майхны хаяагаар хариугүй орж ирэх нь ээ. Нуруу өөд хүйт оргив. Эрүүтэй ярзгар шүдтэй тэр хохимой хүнхэр хар нүх болсон нүдээрээ над руу яг эгц харж байв.”⁶ гэсэн нь “Би” баатрын сүүлчийн удаа эргэж ирсэн, эхнэр Цэнгэлээ бүрмөсөн алдаж, Гөлгөөгийн талаар таагүй мэдээ сонсохын ёр билиг байв. Мөн зохиолын гол үйл явдал өрнөх “Сүжгийн усны хонд” дахь “хүн тавьдаг газар”, яст Нямжавын паянтай явдал зэрэг туужийн үйл явдлыг хөтлөх, өрнүүлэхэд чиглэсэн олон тооны “ёр билиг”-ийн чанартай уран дүрслэл буйг дурдахад хангалттай юм.

Хоёр. Зохиомжийн тусгай бүрдэл хэсгүүд зохиол бүрд харилцан адилгүй харьцаа, тун хэмжээгээр ордог ба дүрслэл, уран сайхны бие даасан тусгай үүрэг бүхий бүрдэл хэсэг гэж үзвэл энэхүү туужид “өдрийн тэмдэглэл” хэлбэрээр Гөлгөөгийн амьдралыг Цэнгэлийн нөхөр хөдөө хүргэнийдээ амарч ахуйдаа малын эрэлд явах зам зууртаа хээр гадаа таарсан хайгуулчийн майханд ороод сураггүй алга болсон эхнэрийнхээ зургийг олсон ба мөн Гөлгөөгийн “Өдрийн тэмдэглэл”-ээс /зохиолд нийтдээ 39 өдөр хөтөлсөн урт, богино хэмжээний өдрийн тэмдэглэл/ түүний бага нас ба амьдралын үүх түүх, туулсан зам, хэрэг явдлуудыг сонирхолтой байдлаар тайлж өрнүүлэх өвөрмөц маягийн зохиомжийг ашигласан буй. Энэ тухайд С.Байгалсайхан: “Ийм л дүрээр, ийм л хүмүүсийн муу муухай амьдралыг Гөлгөөгийн өдрийн тэмдэглэлээр нээхдээ “Би” баатар буюу Цэнгэлийн нөхөр тэр бүхнийг унхисанаар уншигчдад хүрч байгаа нь үнэхээр онцлог болжээ.”⁷ гэжээ.

Туужийн гол үйл явдал зохиолын баатар Гөлгөөгийн бага нас, туулсан амьдралын зам, хайр сэтгэлийн асуудлууд, төрүүлсэн эх, хойд эцэг, орлогч сайд, Цэнгэл, Туяа, Саргай, Цогтын дүрийг өдрийн тэмдэглэл маягаар хөтлөн, зохиолын гол утга, үндсэн үйл явдал, дүрүүдийн зан чанар, төрх байдлыг товчоолон хурааж, олныг нуршихгүй сонирхолтойгоор уншигчдад хөтлөн хүргэсэн нь зохиолчийг мэргэжлийн зохиолч төдийгүй бусдаас ялгардаг ур чадвартан болохыг нь харуулах билээ.

Тууж зургаан хэсэгтэй, үйл явдал нь эн тэнцүү хоёр шугамаар өрнөнө. Эхний хэсэг нь “Би” баатрын үйл явдлаар шууд өрнөх бол удаах нь Гөлгөөгийн “Өдрийн тэмдэглэл”-ээр өнгөрсөн цаг хугацааны явдлуудыг нөхөн тайлах, тайлан өрнүүлэх шугам нь тодрох ажээ. Өдрийн тэмдэглэлийн хоёр дахь хэсэг “7 сарын 9”-ний өдрөөр эхэлж, он цагийн хувьд өдөр бүрээр биш сард 2-3 удаа тэмдэглэл хөтөлжээ. Тэмдэглэлийг ерөнхий агуулгаар нь хэд хэд хуваах боломжтой бөгөөд Цогт, Саргай, Батаа, Туяа, Сараа нарын тухай хэсэг бусад өгүүлэмж ба тухайн цаг үеийн залуус хөнгөн хуумгай амьдрал, шалиг самууны нууцлаг ертөнц рүү татагдан орж буйг Саргай нарын зугаалгын үеийг өгүүлсэн тэмдэглэлээр нөхжээ. Эл бүхний эцэст Гөлгөө ээжийгээ санан дурсах, бага насны хэрэг явдал, мөн Туяа, түүний эцэг, Гөлгөөгийн ажил мэргэжил, Цэнгэл ба нууц амраг, хээрийн шинжилгээний ангийн тухай учир зүйн дагуу үйл явдлаа өрнүүлсэн аж.

Мөн, оруулга, үглэл, дотоод ба харилцан яриа, ганцаарчилсан яриа сэлт мөн зохиомжийн зүйлс харилцан адилгүй хэмжээгээр дүрслэл, уран сайхны үүргээр орж байна.

⁶ Норов Д (2001), “Хөх туужис”, УБ., 71-р тал

⁷ Байгалсайхан С (2014) нар, “Монголын орчин үеийн уран зохиолын түүх IY”, ШУА. ХЗХ. УБ., 180-р тал

Оруулга: Зохиолын эхэнд “Би” баатрынд очихдоо “Сүжийн усны хонд” нь нутгийнхны цэрвэж ширвээтдэг газрыг “Яст цагааны паян”⁸ яриагаар оруулжээ. Тухайлбал **Үглэл яриа:** “Үхээн дорой яваадаа бухимдан, холын явдалд тээртэй хэмээн буу үүрээгүйдээ харамсаж, бага ахуйд найман чоно, арван дөрвөн чононд идүүлсэн хүнийг ч дуулж асан нь санаанд хутгалдан орж ирэв.”, **дотоод яриа:** “Цэнгэл тэр хоёр ямар холбоотой? “Нохой шиг үнэнч” гэж яагаад бичсэн юм бол? Нохой эзэндээ үнэнч гэдэг... Хотыг манаж, хонийг нь дагаж, шавхруу ууж, яс хэмлэж хааяа зодуулавч эзэндээ үхэн үхтлээ үнэнч зүтгэдэг хоточ нохой нь болоо юу? Эсвэл хоолны сайныг идэж эрхлэхээс өөр юмгүй байж, ядуу хүнээс илүү ямбалан жаргадаг хот газрын баян эзний цатгалан нохойг бодож ингэж бичсэн юм болов уу. Гэвч нохой бол нохой. Хуцахаас өөр хүнд юу хэлнэ билээ. Түүнтэй өөрийгөө адилтгах болтлоо доройтсон гэж үү дээ.”, **ганцаарчилсан яриа:** “Миний сэтгэлд асар их зөрчилдөөн болдог. Тэр маань намайг хэдэн хэсэг тасчин хувааж, зовоон шаналгаж, заримдаа нэгдэн дийлж, намайг дийлсний найр хийн, сүнс сүлдээр минь тоглодог. Заримдаа хар хор, атаа жөтөө, үзэн ядалт, уйтгар, цөхрөл болж байдаг. Заримдаа хэн нэгнийг, ихэнхдээ өөрийгөө үзэн ядаж жигшихэд хөтөлдөг. Энэ чинь л би юм” гэх зэрэг олон жишээ туужид бий.

Судлаачид, зохиолчийг ардын дууны арга барил, онцгой маягийн элементүүдийг чөлөөтэй ашигладаг онцлогтойг олонтоо дурджээ. Тэгвэр “Тэжээвэр” туужид ч ардын дуунаас хэдэнтээ шигтгэл авсан нь тодорхой үүрэггүй, сонгосон дууны агуулга Туяа, Цэнгэл хоёр, мөн Гөлгөөгийн хайр сэтгэл ба зөрчлийг хялбарчилсан оролдлого гэж болно.

Гөлгөөгийн төрсөн өдрөөр ирсэн хоёр бүсгүй хоорондоо тааламжгүй байх үед Гөлгөө хундага өргөн ая өргөхийг хүсэхэд Туяа:

Хамбаны чинь хээ элэгдэнэ дээ, Сүнжидмаа
Ханилсан нөхөр чинь хэрэг болно, Сүнжидмаа яа хө
Хар сайхан үсийг чинь цайгаад ирэхийн цаг дээр нь хө ай, ай Сүнжидмаа
Хаалга үүдээ нээгээд суусан ч
Харж үзэх хүнгүй болно хө ай хө, Сүнжидмаа минь..гэж дуулсанд сайхан
хүүхэн Цэнгэлд эгдүүцнэ.

Харин Цэнгэлийн ээлж ирэхэд өөрөөс нь өөр бүсгүйг төрсөн өдөртөө урьсан Гөлгөөд хандан:

“Түүхий төмрийг дарханд тушаалаа
Түлхүүр хийнэ үү, цоож хийнэ үү өөрөө л мэдээрэй хө
Төрсөн биеийг чамдаа тушаалаа
Түшээд авна уу, түлхээд хаяна уу, өөрөө л мэдээрэй хө” гэж дуулснаар хоёр бүсгүйн хайр сэтгэлийн зөрчлийг их хурцатгасан мэт боловч анх удаа нүүр тулан уулзсан хоёр бүсгүй дээрх дууг сонгон дуулсан нь үнэмшил муутай болжээ.

⁸ Норов Д (2001), “Хөх туужис”, УБ., 8-9-р тал.

ДУГНЭЛТ

Зохиолч Д.Норовын хүүрнэл зохиолын ур чадвар, туурвилын өвөрмөц аргууд нь сэтгэлгээний эрэл төдий байсангүй монгол уран зохиолын ур зүйн шинэтгэлд оруулсан томоохон өвөрмөц “*шинэтгэл-сэтгэлгээ-туршлага*”-ын цогц гэж болно.

- Зохиолчийн туужис, өгүүллэгийн дүрийн сэтгэл зүйн орчин ахуй, тэдгээрийн сэтгэл-оюун санааны дотоод ертөнцийг нээх, сэтгэх хэв маяг ба ахуй хоорондын гүн шүтэлцээ, зоримог туршилтууд уншигчдын анхаарал, сонирхлыг татаж буй нь ур чадварын илрэл болно.

- Зохиолчийн ертөнцийг үзэх үзлээ тухайн цаг үеийн нийгмийн төлөөлөл Гөлгөө, сайд, Цэнгэл, Цогт, Туяа, хуурамч яруу найрагч, Саргай нарын дүрээр уншигчдад таниулахдаа айдас, ёр билгийн аргыг ашигласан ба зохиолчийн үзэл санаа, ёс суртахууны асуудлыг хөндөх зорилттой нь уялдаж, зохиомжийн зүйлсээс өдрийн тэмдэглэл, оруулбар, оруулга, үглэл яриа, ганцаарчилсан яриа зэргийг өргөн ашигласан нь Гөлгөө ба бусад дүрийг төгс болгон бүтээхэд сайн туршлага болжээ.

НОМ ЗҮЙ

1. Байгалсайхан С (1998), “Уран дүрийн онолын лекцүүд”. УБ.,
2. Байгалсайхан С (2014) нар, “ХХ зуун тууж судлал”. УБ.,
3. Байгалсайхан С (2014) нар, “Монголын орчин үеийн уран зохиолын түүх IY”. УБ.,
4. Галбаатар Д (2012), “Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл нэвтэрхий толь”. УБ.,
5. Галбаатар Д нар (2007), “Монгол уран зохиолын дээжис” 86 дугаар боть. УБ.,
6. Дулам С (2011), “Монгол бэлгэдэл зүй” IY боть. УБ.,
7. Норов Д (2001), “Хөх туужис”. УБ.,
8. Энхбаяр С (2011), “Уран зохиолын онол”. УБ.,
9. Юнг К (2011), “Бэлгэдэлт амьдрал”, УБ.,

SUMMARY

D.Norov's artistry and writing techniques of the fiction were not only the search of thinking but also the combination of “renovation-thinking-experience” to the artistic development of the Mongolian literature.